



I-XI/2021

Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 13




Төмөр замаар тээсэн ачаа өмнөх сараас 119.5 мянган тонноор буурлаа

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2021 оны эхний 11 сард 29.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 (7.0%) сая тонноор өсжээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд дотоодод тээсэн ачаа 1.4 (13.9%) сая тонн, импортын ачаа 295.1 (10.7%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 11 дүгээр сард 2.7 сая тонн болж, өмнөх сараас 119.5 (4.2%) мянган тонноор буурчээ.

Энэхүү бууралтад төмрийн хүдэр 91.4 (14.7%) мянган тонн, барилгын материал 86.3 (32.5%) мянган тонноор буурсан нь нөлөөлсөн байна.


ХҮСНЭГТ 1. ТӨМӨР ЗАМААР ДОТООД, ГАДААДАД ТЭЭСЭН АЧАА, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний 11 сараар

Үзүүлэлт	2019 I-XI	2020 I-XI	2021* I-XI
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	83.0	82.7	81.2
Барилгын материал	10.1	10.4	12.9
Мод, модон материал	0.6	0.5	0.4
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.9	0.9
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.4	0.9	0.7
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.3	1.6	1.1
Бусад	2.7	3.0	2.7

Төмөр замын тээврээр 2021 оны эхний 11 сард уул уурхайн бүтээгдэхүүн 1.0 (6.0%) сая тонн, барилгын материал 710.1 (32.8%) мянган тонн, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 22.3 (11.8%) мянган тонноор өсөж, харин хар төмөр 77.8 (24.1%) мянган тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 20.8 (11.2%) мянган тонноор тус тус буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2021 оны эхний 11 сард 248.8 (давхардсан тоо) мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (87.3%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Ковид-19 өвчнөөс үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээврийг хязгаарласан нь нөлөөлсөн байна. Төмөр замын тээврээр зорчигчид 2021 оны 11 дүгээр сард 102.0 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 18.9 (22.8%) мянган хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, мянган хүн, сараар




Төмөр замын тээврийн орлого 2021 оны эхний 11 сард 726.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.9 (2.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд барилгын материал, нүүрс тээвэрлэлт өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2021 оны 11 дүгээр сард 66.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.0 (1.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Агаарын тээвэр

Агаарын тээврээр тээсэн ачаа 2021 оны эхний 11 сард 5.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.7 (2.1 дахин) мянган тонноор өссөн байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, тонн, сараар



Агаарын тээврээр 2021 оны эхний 11 сард дотоодод 52.6 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 42.5 (44.7%) тонноор буурсан байна.

Харин олон улсад тээсэн ачаа 5.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (2.2 дахин) мянган тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2021 оны 11 дүгээр сард 1.2 мянган тонн болж, өмнөх сараас 701.0 (2.3 дахин) тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 684.9 (2.2 дахин) тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

Эх үүсвэр:

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын

Мөнгө, санхүү, үйлчилгээний

статистикийн ахлах статистикч О.Мандахзориг

Утас: (976-51)-264797

